



**ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН**  
**ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2025 оны 9-р сарын 8-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороонд байрлах Говь ХК, Сургалтын танхимд боллоо. Хурлыг Говь ХК-ийн ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан даргалж, ТУЗ-ийн хараат бус гишүүд Д.Гэрэлмаа, А.Жаргалмаа, Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ нар оролцов.

**ХУРЛЫН НЭЭЛТ**

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, зочид төлөөлөгчид өө. "Говь" ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал эхлэхэд хэдхэн хором үлдлээ. Та бүхнийг суудлаа эзлэн, гар утас, төхөөрөмжөө чимээгүй горимд тохируулахыг хүсье. Хурлын ирц бүрдсэн тухай албан ёсоор мэдэгдэнэ үү хэмээн Тооллогын комиссын дарга Хатагтай Мөнхзулыг урьж байна.

**1. ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ**

*Тооллогын комиссын дарга Т.Мөнхзул танилцуулав.*

Тооллогын комиссын дарга Т.Мөнхзул бүртгэлийн өдөр 2025 оны 8-р сарын 18-ны өдөр байсныг дурдаж, бүртгэлийн өдөр Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 780,112,500 байгаагаас хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх арга хэлбэрээр 14,866,699 буюу 1.91% саналын эрхтэй 475 хувьцаа эзэмшигч, 9-р сарын 8-ны өдрийн хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр 682,231,660 буюу 87.45% саналын эрхтэй 31 хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт хурлын ирц 89.36% болсон тухай хурлын даргад мэдэгдэж, хурлын ирц бүрдэж Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтад заасан шаардлагыг хангасныг танилцуулав.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Тооллогын комиссын даргадаа баярлалаа. Ийнхүү "Говь" ХК нь 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа хуульд заасан хугацаа, журмын дагуу зарлан нээж байна.

Хурлын ирц бүрдсэн тул албан ёсоор нээж үг хэлнэ үү хэмээн Хурлын дарга, ТУЗ-ийн гишүүн Ноён Баатарсайхан таныг урья.

**2. ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ**

*ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан танилцуулав.*

**Хурлын дарга Ц.Баатарсайхан:** Сайн байцгаана уу, Нийт хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хурлын ирц бүрдсэн тул Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал албан ёсоор нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хурлын дэг болон компанийг төлөөлж хуралд оролцож буй хүмүүсийг танилцуулъя. ТУЗ-ийн хараат бус гишүүд болох Гэрэлмаа, Жаргалмаа болон Хүрэлбаатар нар, ТУЗ-ийн ердийн гишүүд болох миний бие мөн Хуулийн хэлтсийн дарга Цасчихэр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Сэлэнгэ нар оролцож байна.

Хурал 14:00 цагт эхлэн, 15 цаг 30 минутад дуусахаар төлөвлөсөн байгаа. Энэ удаагийн хурлаар 2 асуудал хэлэлцэнэ.

1-р асуудал бол Компанийн хэлбэрийг өөрчлөх асуудал байгаа. ТУЗ-ийн дарга миний бие танилцуулна.

2-р асуудал болох Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийн төслийг Хуулийн хэлтсийн дарга Цасчихэр танилцуулна.

Та бүхэнд тараан өгсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд хурлын хөтөлбөр болон хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, хурлаас гарах тогтоолын төслийг оруулсан байгаа. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Баярлалаа. Одоо хэлэлцэх асуудлын танилцуулга хэсэг рүү шилжье. 1-р асуудал буюу Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой танилцуулгыг ТУЗ-ийн дарга Ноён Баатарсайхан танилцуулна.

### **3. ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫГ ТАНИЛЦУУЛАХ**

#### **3.1 Компанийн хэлбэр өөрчлөх**

*ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан танилцуулав.*

**ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан:** Та бүхэн компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцийг харж байна. Одоогийн байдлаар Говь ХК-ийн 89.7 хувийг толгой компани Таван Богд Холдингс болон хамаарал бүхий этгээд эзэмшиж байна. Бусад буюу жижиг хувьцаа эзэмшигчид ойролцоогоор 10 хувийг эзэмшиж байна.

Засаглалын талаас харвал шийдвэр гаргалтыг нэг тал бүрэн гаргах боломжтой болж, бусад хувьцаа эзэмшигчдийн оролцоо бага болсныг харуулж байна. Үүнээс үүдээд хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох нь өнөөдрийн гол хэлэлцэх асуудал байгаа. Ер нь бол яагаад хязгаарлагдмал хариуцлагатай компани болж байгаа вэ гэвэл шийдвэр хурдан гаргах юм. Өнгөрсөн хэдэн жилийн гол асуудал юу байсан бэ гэвэл КОВИД-19-тэй салшгүй холбоотой. Говь ХК-ийн нийт борлуулалтын 50 орчим хувийг экспорт болон Монголд ирдэг жуулчид эзэлдэг байсан. КОВИД-19-тэй холбоотойгоор урт хугацаанд компани санхүүгийн хувьд өрийн харьцаа нэмэгдсэн. Тэгэхээр ХХК болсны дараа Таван Богд Холдингс ХХК-ийн зүгээс нийт 60 орчим тэрбум төгрөгийн хувьцаа гаргаж компанийн санхүүг улам сайжруулж, дэлхийн зах зээлд гарах процессыг хурдтай урагшлуулахын төлөө бид энэхүү саналыг танилцуулж байна, баярлалаа.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Баярлалаа. Хэлбэр өөрчлөхтэй холбоотой төсөл, журам болон процессын талаар Хуулийн хэлтсийн дарга ноён Ц.Цасчихэр үргэлжлүүлэн дэлгэрэнгүй танилцуулна.

#### **4.2 Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийн төслийг танилцуулах**

*Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр танилцуулав.*

**Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би ХХК болохтой холбоотой төсөл болон журам, мөн ХХК-ийн анхны дүрмийг та бүхэнд дэлгэрэнгүй танилцуулъя.

Та бүхэн тараах материалын 9-р хуудсыг харна уу. Төслийн гол 4 нөхцөлийг танилцуулъя. Зорилгын хувьд ТУЗ-ийн даргын хэлсэнчлэн хувьцаа эзэмшигчдийг үргэлжлүүлэн алдагдалд оруулахаас урьдчилан сэргийлэхээс гадна, засаглалын хувьд хялбар бүтцэд шилжиж шийдвэр гаргалтын хурд, дотоод зохион байгуулалтад өөрчлөлт оруулснаар зах зээлээ тэлэхэд илүү дөхөм болохыг зорьж байна. Энэ төсөл нь та бүгдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэгдэнэ. Журам, хугацааны тухайд хууль, холбогдох төрийн байгууллагуудын журамд нийцүүлэн энэ оны 4 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байгаа.

Та бүхэнд төслийн үе шат, зарим өөрчлөлтийг төлөвлөж буй хугацааны хамт дэлгэрэнгүй танилцуулж тайлбарлая.

Нэгдүгээрт, бид бэлтгэл үе шатанд ХЭХ зарлах, бичиг баримтын бүрдэл хангаж хуулийн шаардлагын дагуу компанид сүүлийн хагас жилийн тайланд хөндлөнгийн санхүүгийн аудит оруулах ба эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнийг тогтоолгох байна.

Хоёрдугаар үе шат нь өнөөдөр та бүхэн хэлбэр өөрчлөх болон ХХК-ийн анхны дүрмийг хэлэлцэн батлах эсэхийг шийдвэрлэх юм. Үүний дараа, хэлбэр өөрчлөх шийдвэр гарвал Хөрөнгийн биржид нээлттэй арилжааг шаардах эрхийг хэрэгжүүлж дуустал хугацаанд түр зогсоолгох хүсэлтийг гаргах ба Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчийн хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэр гаргаж, энэ ажиллагаа маргаашаас эхэлнэ. Та бүхэнд энэхүү шаардах эрхийг хэрэгжүүлэх ажиллагаа, түүнд орсон зарим өөрчлөлтийг дэлгэрэнгүй танилцуулъя.

Маргааш буюу 9 сарын 9-нд Компанийн тухай хуулийн 53, 54, 55 дугаар зүйл буюу хувьцаа эзэмшигчийн шаардах эрхийг хэрэгжүүлэх, эргүүлэн худалдан авах хувьцааны нэгж үнийг тогтоох, үүнийгээ хэрхэн хийх журмын талаар ТУЗ-өөс шийдвэрээ гаргана. Хуульд зааснаар ажлын 5 хоногт буюу 9 сарын 11-нд, дараа нь давтан байдлаар 9 сарын 26-нд тус тус олон нийтэд аль болох олон мэдээллийн сувгуудаар нэлээд хүртээмжтэй хэлбэрээр зарлан мэдээлэхээр төлөвлөөд байна. Төсөлд зарим өөрчлөлт орсныг та бүхэнд хүргэе.

Бид төслийг мэдээлснээс хойш холбогдох төрийн байгууллагуудтай уулзаж тэдний журам, гэрээний нөхцөлийн дагуу зарим өөрчлөлтийг хийлээ. Тухайлбал, худалдах шаардлага гаргасныг худалдан аваад, хүсэлт гаргаагүй хувьцаа эзэмшигчдийн мөнгийг шилжүүлбэ гэсэн нөхцөл байсан боловч СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журам болон ҮЦТХТ-ийн журмын дагуу 2 сарын хугацаа дууссаны дараа хүсэлт гаргаагүй бол хувьцаа эзэмшигчээр үлдэнэ гэж журамласан байна. Үүний дагуу өөрчилж, үлдэх хүсэлт хүлээн авах, шаардлага гаргасныг л худалдан авна. Хувьцаа эргүүлэн худалдах болон хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтүүдийг компани болон үнэт цаасны компани дээр хүлээн авна. Бид бүх хүсэлтийг компани дээр нэгтгэж ҮЦТХТ рүү илгээснээр аль нэгэн хувьцаа эзэмшигчийн хүсэлт шийдвэрлэгдэхгүй орхигдох эрсдэлгүй гэж тооцоод байна.

Бусад хувьцаа эзэмшигчдийн анхаарах 2 зүйлийн эхнийх нь энэ бөгөөд энэ үйл ажиллагаа ажлын 30 хоног буюу 9 сарын 11-нд олон нийтэд мэдээлсэн өдрөөс эхэлж 10 сарын 23-аар дуусгавар болно. Аль нэг хүсэлт гаргаагүй хувьцаа эзэмшигчийн хувьцаанд оногдох мөнгийг шилжүүлэх гэдгийг дансанд байршуулах гэж өөрчилж зарчмын хувьд адил буюу тодотгож өгсөн. Мөн зохицуулалтад эцсийн шийдвэр гаргах СЗХ-ны журмын заалтыг оруулж өгсөн байна. Та бүхэн танилцаарай. Бид бусад нийт хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ногдох мөнгийг журамд заасан хугацаанд бүрэн байршуулна.

Одоогоор нэгж хувьцааны үнэлгээний шийдвэр гараагүй болохоор тоог дэлгэрэнгүй хэлэх боломжгүй байна. Өнөөдрийн хаалтын ханш гарсны дараа Монголын хөрөнгийн биржээс тодорхойлолт ирсний дараа буюу маргааш өглөө үүнийг харах боломжтой.

Хоёр дахь анхаарах зүйл нь, хувьцаа эзэмшигч та 2 сарын хугацаанд буюу мөнгө байршуулснаас хойш ямар нэгэн хүсэлт гаргаагүй бол СЗХ-ны журмын дагуу хувьцаа эзэмшигчээр үлдсэнд тооцогдоно. Энэ хугацааг бид 9 сарын 15-аас 11 сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд гэж төлөвлөж байна.

Эргээд төслийн үе шаттайгаа танилцацгаая. Шаардах эрх хэрэгжүүлсний дараа бид мэдээллийг Монголын хөрөнгийн биржид 11 сарын 5-ны өдрийн дотор гаргаж, Биржээс ажлын 3 хоногт үнэт цаасны бүртгэлээс хувьцааг хасах эсэх шийдвэр гаргах, хассан шийдвэр гарсан бол бид СЗХ-нд хүсэлтээ гаргана. СЗХ-оос хасах шийдвэр гаргах ажиллагаа нь хорооныхоо хуралдаанаар шийдэгддэг юм байна. Үүнийг 11 сард багтана гэж харж байгаа. Амжихааргүй бол 12 сард багтана гэж үзэж байна. Мөн төслийн төгсгөлд ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн

хуралдах үе шатыг оруулсан байгаа. Хэлбэр өөрчилсөн бүртгэл хийгдсэний дараа ХЭХ зарлах хуулийн шаардлага байгаа болохоор төсөлд оруулсан байна.

Журмын тухайд та бүхэнд танилцуулсан үе шат болон зарим заавал мэдэх үйл ажиллагаа, эрхийн талаар хэрхэн журамласныг танилцуулъя. Бид нээлттэй компаниас хязгаарлагдмал хариуцлагатай компани болж өөрчлөгдөнө. Ялгаа нь хувьцаа эзэмшигч та бүхэн өөрсдийн эзэмшиж буй хувьцаагаа хоёрдогч зах зээл дээр арилжаалах боломжгүй болно. Зорилгыг мөн сая танилцуулсан. Шийдвэрийн тухайд хувьцаа эзэмшигчдийн хурлын 50-аас дээш хувийн ирцтэй, дийлэнх олонхын саналаар шийдвэрлэх юм. Үйл ажиллагааг сая мөн дэлгэрэнгүй танилцуулсан.

Зарчмын хувьд 2 өөрчлөлт орсон. Өмнөх хэсэг дээр мөн тайлбарласан, одоо дахин тайлбарлая. Та шаардах эрхийн болон ҮЦТХТ-тэй гэрээ байгуулж мөнгө байршуулснаас хойш 2 сарын хугацаанд ямар нэгэн хүсэлт гаргаагүй бол СЗХ-ны журам, ҮЦТХТ-ийн журам, түүний хавсралтаар баталсан гэрээний нөхцөлийн дагуу шууд хувьцаа эзэмшигчээр үлдсэнд тооцогдоно гэдгийг дахин анхаарна уу. Мөн журамд орсон өөрчлөлт нь бид хүсэлтүүдийг компаниараа дамжуулж авахаар нэмсэн. Энэ нь хүсэлт орхигдохгүй байх ба бид өөрсдөө бүрэн хянаж болох давуу талтай.

Та бүхэнд ойлгомжгүй, дутуу ойлгосон асуудал байвал би асуулт хариултын хэсэгт хариулахад бэлэн байна.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Баярлалаа. Үргэлжлүүлэн 2-р хэлэлцэх асуудал буюу Компанийн шинэчилсэн дүрмийн төслийг Хуулийн хэлтсийн дарга та бүхэнд танилцуулна.

### **3.2 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай танилцуулах**

*Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр танилцуулав.*

**Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр:** Та бүхний хэлэлцэж шийдвэр гаргах 2-р асуудал бол ХХК-ийн анхны дүрэм юм. Тараах материалын 14 нүүрнээс эхэлж байна.

Та бүхэн танилцсан учир би гол зүйлсийг тайлбарлаж танилцуулъя. Компанийн нэр хэвээрээ байна. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд одоогийн бүтцэд өөрчлөлт орохгүй гэж харж байна. Үүнд Таван Богд Холдингс болон Олон нийт байгаа. Олон нийт гэдгээрээ 5 хувиас доош хувьцаа эзэмшигчдийг тодорхойлсон. Одоогийн байдлаар бусад хувьцаа эзэмшигчдийн хувьд 2 хувиас дээш эзэлж байгаа иргэн, хуулийн этгээд байхгүй байна гэдгийг мөн дурдъя. Хувьцаа эзэмшигчдээр үлдсэн мэдээллийг арилжаа эрхлэх байгууллагын мэдээллийг үндэслэн гаргана. ХХК болсны дараа шилжилт өөрчлөлтийн мэдээллийг тусад нь журамлах нь зүйтэй гэж харж байгаа. Мэдээж, компани нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Таван Богд Холдингс ХХК-ийн охин компани байна.

Үйл ажиллагааны чиглэлийн хувьд өөрчлөлт байхгүй. Компанийн хувьцаа эзэмшигчийн оролцоо хуулийн шаардлагын дагуу орсон байгаа. Оролцооны хэм хэмжээ шаардах эрхийг хэрэгжүүлж СЗХ-ны 2 сарын хугацаа дууссаны дараа тодорхой болохоор байгаа. Компанийн удирдлагын хувьд хэвээрээ. Мөн ХЭХ, ТУЗ, Гүйцэтгэх захирал гэсэн бүтэц хэвээр байна. ХЭХ-ын эрх хэмжээ хэвээрээ байгаа. ТУЗ-ийн хувьд гишүүдийн тоо 5 болж буурсан, засаглалын хувьд хараат бус гишүүдтэй байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан бусад асуудлууд хуулийн дагуу орсон байна. Энэхүү дүрэм нь ХХК болж анх Улсын бүртгэлд бүртгэгдэхэд шаардагдах ач холбогдолтой ба ХХК болсны дараа яаралтай ХЭХ зарлаж ТУЗ-ийн гишүүд сонгох болон бусад асуудлыг хэлэлцэх төлөвлөгөөтэй байгаа. Та бүхэнд баярлалаа. Танилцуулга дууслаа.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Баярлалаа. Одоо хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариултын хэсэгт шилжье. Асуулт хариултын хэсэг маань 20 минутын хугацаанд үргэлжилнэ. Хүн тус бүр 2 минутад багтаан асуултаа асуухыг анхаарна уу. Та асуулт асуух хүсэлтэй бол гараа өргөвөл зааланд байгаа манай ажилтнууд танд микрофон өгөх болно.

## **4. АСУУЛТ ХАРИУЛТ**

/Нийт 20 минут/

### **АСУУЛТ 1.**

**Хувьцаа эзэмшигч 1:** Хувьцаагаа эргүүлж худалдаж авах нэгж үнэ нь одоо тодорхой биш юм уу? Хэд байх вэ?

**ХАРИУЛТ:**

**Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр:** Үнэлгээ бол хийлгэсэн байгаа. Хуульд зааснаар шаардах эрх үүссэн үеийн ханшаартогтооно гэсэн байгаа. Монголын хөрөнгийн биржид сүүлийн 6 сарын дундаж ханшийн тодорхойлолт авах хүсэлт бид өгсөн байгаа. Тэр нь өнөөдөр орой эсвэл маргааш өглөө ирнэ. ТУЗ маргааш хуралдаад шаардах эрхээ хэрэгжүүлэх талаарх тогтоолыг гаргахад үнэ тодорхой болно гэсэн үг. Бид 9 сарын 9-нд шийдвэр гаргаад энэ ажиллагааг 9 сарын 11-нд олон нийтэд мэдээллэнэ.

## **АСУУЛТ 2.**

**Хувьцаа эзэмшигч 2:** Үлдэж байгаа жижиг хувьцаа эзэмшигчдэдээ хурлынхаа мэдээллийг яаж өгч, яаж харилцах вэ?

**ХАРИУЛТ:**

**Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр:** Шаардах эрх маань 9 сарын 11-нд олон нийтэд мэдээлэгдээд 10 сарын 23 хүртэл явагдана. Та энэ хугацаанд хувьцаагаа компани дээрээ эргүүлж худалдаж болно. Үгүй бол та хувьцаа эзэмшигчээрээ хэвээр үлдэнэ гэсэн үг. ХХК болсны дараа яаж харилцах вэ гэвэл тухайн үед хэлбэр өөрчилсний дараа олон нийтэд мэдээллэнэ.

## **АСУУЛТ 3.**

**Хувьцаа эзэмшигч 3:** Сайн байцаана уу? Та бүхэнд өнөөдрийн мэндийг хүргэе. Хувьцаа эзэмшигч Энхтөр байна. Би хувь хүнийхээ хувьд хөнгөн үйлдвэрийн салбарт 40 гаруй жил ажиллаж байгаа бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд байнга оролцдог, санал бодлоо хэлдэг ийм хүн байна. Тэгэхээр Говь ХК-ийг ХХК болно гэдгийг сонсоод жаахан харамсах сэтгэл төрсөн. Яагаад гэхээр олон улсад ч, монголд ч нээлттэй компани байх нь компанийн засаглалын хамгийн сайн хэлбэр гэж үздэг шүү дээ. Тэгэхээр хаалттай компани болох үндсэн шалтгааныг ихэд шуурхай ярьчихлаа. Хуулийн зөвлөх ч хэллээ. Одоо 9 ТУЗ-ийн гишүүнтэй, дараа нь 5 болох юм байна. Гишүүд маань ч бараг хэвээрээ байна. Дийлэнх олонхийг нэг хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа компанийн хувьд шийдвэр гаргалт дээр нэг их удаад байдаг зүйлгүй байх гэж би дотроо боддог.

Ерөнхийдөө Говь бол их сайхан компани. Манай хөнгөн үйлдвэрийн салбарыг тэргүүлдэг, манай салбарыхан жишээ авдаг, Хөрөнгийн бирж дээр бүх зүйл нь нээлттэй байдаг болохоор бид тэрийг нь үздэг, дуурайдаг ийм сайхан компани. Энэ маань одоо байхгүй болох гэж байна. Нэгэнт том хувьцаа эзэмшигч шийдэх тул бид бараг энэ талаар яриад ч хэрэггүй байх. Ерөнхийдөө асуулт асуухад өөр ямар шалтгаан байв? Заавал үүнийг яаран шийдэх хэрэг байв уу? Олон улсын зах зээлд гарахад нэр хүнд унах уу, үгүй юу? Үүнийг одоо бодолцсон уу? гэж асуумаар байна. Баярлалаа.

**ХАРИУЛТ:**

**ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан:** Олон улсад нэр хүнд унаад байх зүйл бол байхгүй. 90 орчим хувийг эзэмшиж байгаа Таван Богд Группийн зүгээс нэмж хөрөнгө оруулж зээлийг нь бууруулж илүү хурдтай үйл ажиллагаа явуулна. Одоохондоо үйлдвэрлэлийн тоо хэмжээг хэвээр хадгалж, ирээдүйд нэмэгдүүлнэ. Өнөөдөр бид ЕХ, АНУ, Англи, Хятад гэсэн зах зээлүүдэд үйл ажиллагаа явуулж байна. Энэ онд багтан Говь БНСУ-д охин компани байгуулж онлайн үйл ажиллагаагаа эхлүүлэх гэж байна. Ер нь КОВИД-19-ийн нөхцөл байдал сайжраад Говь компанийн 8-р сарын цэвэр ашиг 4.1 тэрбум гарсан. Гэхдээ 1-7 дугаар сарын алдагдал өндөр байсан ч энэ ондоо багтан ашигтай компани болно. Гэхдээ компанийн үрт удаан хугацааны хөгжил, шийдвэр гаргалтаа бодохоор ер нь ХК байснаас ХХК болж шийдвэрээ хурдан гаргаад, хөгжөөд явна.

Монгол Улсад жилд 18,000 тонн ноолуур гардагаас Говь ХК 500 орчим тонныг л авдаг. Би Говь компанийг олон жил удирдсан. Арай илүү хурдан дэлхийн зах зээл дээр гарчих болов уу гэсэн

бидний тэр бодол харамсалтай нь биелсэнгүй. Гэхдээ бид заавал Говь компанийг олон улсын компани болгоно. Говь компанийн нийт зээл санхүүжилт зэрэг бүх зүйл дээр Таван Богд Групп болон миний зүгээс баталгаа гаргаж өгч авдаг. Хойшдоо ч энэ нь үргэлжлээд аль болох богино хугацаанд Говь компанийг өөрөөрөө өр зээлгүй болгоно.

Хаалттай компани болсон ч зайлшгүй үлдэхийг хүсч байгаа хүмүүст хувьцаа эзэмшигчээрээ үлдэх боломжийг олгож байгаа. Компанийн хувьд бол хойшид илүү үнэ цэнтэй компани болгохын төлөө бид бүхэн илүү анхаарч байгаа. КОВИД-19 бол бидний олон жилийн бодож байсан боломжуудыг бол үнэхээр байхгүй болгосон. Дэлхийн зах зээл дээр Монгол Улсаас экспортод нүүрс, зэс зэрэг л гардаг. Өөрөөр эцсийн бүтээгдэхүүн бол гардаггүй. Үүнийг бид арай хялбар гаргах болов уу гэж их мөрөөдөж, их мэрийсэн. Гэхдээ Говь дээр гарсан алдаа нь бол арай илүү хурдан томорчих байх гэсэн мөрөөдөлдөө автсан маань миний алдаа байсан юм болов уу гэж би бодож байгаа. Гэхдээ Говь компанийг заавал хөгжүүлнэ. Таван Богд Групп нийт 12,500 ажилтантай. Говь хамгийн сүүлийн тоогоор 1,248 ажилтантай байгаа. Бид орон тоогоо цомхотгож цомхон болгосон. Ер нь өнөөдөр Говь ахиад нэг өөрчлөлт хийж буй том шалтгаан нь бол дэлхийн зах зээл дээр бөөний худалдан авалт хийхэд маш хямд үнээр борлуулах шаардлага гардаг. Дэлхийд яг ингэж бөөний худалдаагаар өрсөлдөх маш амаргүй. Харин одоо бид эцсийн бүтээгдэхүүнээр өрсөлдөөд явж байгаа. Гэхдээ энэ нь бидний бодож мөрөөдөж байгаа шиг бас амар байсангүй ээ.

2023 оноос бид гутал борлуулдаг болсон. Энэ маань өнгөрсөн жил 11,000 ширхэг борлуулагдсан бол энэ жил 30 орчим мянгыг борлуулах хэмжээний компани болжээ. Куртка өнгөрсөн жилээс эхлэж борлуулаад мөн амжилттай явж байгаа. Өнөөдөр та бүхэн мэдэж байгаагчлан манай үнэ бол бусад компаниас өндөр байдаг, харин бусад компани бол ашиггүй боловч үнийн өрсөлдөөн дээр их өндөр өрсөлдөөнтэй байдаг.

Ер нь манай салбарт маш их бэрхшээл байна. Мөн та бүхэн санаж байгаа байх. Нэг хэсэг манай Монгол Улсын Хөгжлийн банк бид бүхнийг дэмжээд явж байснаа нэг өдөр дэмжихгүй гэсэн. Бараг л Хөгжлийн банкны хугацаа нь болоогүй зээлийг хүртэл бид нар КОВИД-19-өөс болоод сунгах шаардлагатай болсон. Тэгтэл сунгаж өгөхгүй байсан. Тэгснээ Говь хугацаандаа мөнгөө төлөхгүй байна гээд цоллож дуудаад байдаг. Энэ бол компанийн нэр хүндэд бодитой хохирол учруулж байсан. Гэхдээ бид энэ бүхнийг нийтэд нь төлөөд дуусгасан.

Өнөөдөр бол Говь дотоодын болон олон улсын банкуудаас зээл аваад явахад ямар ч асуудалгүй зээл авч байгаа. Хөгжлийнхөө дөнгөж эхлэл дээр л ирж байна гэж бодож байгаа. Би өөрөө бизнес хийгээд 30 жил болж байна. Би тэтгэвэрт гарах хүртлээ Говь компанийн ТУЗ-ийн даргын үүргийг гүйцэтгэж Говь-ийг заавал олон улсын компани болгоно гэдэг хүсэл эрмэлзлээсээ буцахгүй гэж бодож байгаа. Та бүхнийг мөн өнгөрсөн хугацаанд Говь компанийн хувьцаа эзэмшигч байж, дэмжиж ажилласанд гүнээ талархаж байна. Тэгэхээр хувьцаагаа зарах уу эсвэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэх үү гэдэг нь та бүхний сонголт гэж та бүхэнд үнэн байдлаар нь хэлмээр байна. ХХК боллоо гээд мэдээлэл хаалттай болно гэсэн үг биш. Бас нэг зүйл хэлмээр байна, гэхдээ амлаад байх зүйл бол биш. Өнөөдрийн хурлын дараа 9 сарын 9-нд хувьцааны үнэ тодорхой болохоор тэр үнээр ХХК болсон ч гэсэн энэ удаад хувьцаагаа зарж амжаагүй хүмүүс байвал Говь ХК хариуцлагатай байж хойшдоо ч гэсэн хувьцаагаа зарахыг хүссэн хүмүүсийн хувьцааг ямарваа нэгэн бэрхшээлгүйгээр худалдаж авах үүрэг хүлээнэ гэж бодож байгаа.

**Хувьцаа эзэмшигч 3:** Говь 8-р сарын байдлаар ашигтай ажилласан бол ХХК болох хүртлээ хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигч нартаа ногдол ашиг тараах уу гэж асуух гэж байсан юм. Ер нь КОВИД-19-өөс хойш ногдол ашиг тараагаагүй. Тэгэхээр 5-6 жил бидэнд ногдол ашиг өгсөнгүй шүү дээ.

**ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан:** 8 сарын байдлаар биш, зөвхөн 8-р сардаа ашигтай ажилласан гэж хэлсэн шүү. 1-7-р сар хүртэл бол 19 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа. Энэ дээр бол ийм байна, ногдол ашиг тараах санхүүгийн боломж бол байхгүй. Харин ч Таван богд компанийн зүгээс зах зээл дээрээс Говийн хувьцааг тогтмол худалдан авч явсаар 89.7 хувь болсон. Хэрвээ бид тэгж аваагүй бол Говийн хувьцаа үүнээс илүү унах эрсдэл байсан.

Тэгэхээр хойшид байнга ийм хариуцлага хүлээж явах боломжгүй тул ХХК болоод нэмж хувьцаа гаргаж санхүүгийн үзүүлэлтүүдээ сайжруулж явъя гээд ийм шийдвэр гаргаж байна.

**Хувьцаа эзэмшигч 3:** Ер нь дэлхийн томоохон компаниудаас дийлэнхийг нь ямар нэг компани эзэмшдэг бол ашиггүй ажилласан тохиолдолд уучлалт гуйгаад, бид өөрсдөө ногдол ашиг авахгүй гээд жижиг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах гэх зүйл байдаг, ийм зүйл байх эсэхийг асуух гэж байлаа. Баярлалаа.

#### **АСУУЛТ 4.**

**Хувьцаа эзэмшигч 4:** Сайн байна уу? Хувьцаа эзэмшигч Цэрэнжав байна. 2-3 асуулт байна 1-рт, 1-2 жилийн өмнө хувьцаа эргүүлэн худалдаж авах шийдвэр гаргаж байсан санагдаж байна. Үүгээр хэр олон хүн хувьцаагаа компанид худалдсан бэ? Одоо өнөөдөр 25,000 хүн хувьцаа эзэмшиж байгаа гэж байна. Гэхдээ сүүлд гарсанаар хэдэн хүн хувьцаагаа худалдаад байгаа вэ? 2-рт, сүүлийн 6 сараар нэгж хувьцааны үнэ тогтоно гэж хэлэх шиг боллоо. Инээдтэй байгаа шүү дээ. Та нар өөрсдөө мэдэж байгаа байх. 240-250 төгрөг байгаа. 250 төгрөгөөр та нар худалдах уу? Инээдтэй байгаа шүү. Өнөөдрийн ханш инфляцаа бодоход ч гэсэн. Тэгэхээр энэ нэгжийн худалдаж авах ханш бол ингэж тогтохгүй болов уу гэж бодож байна. Энэ үндсэн хөрөнгийн үнэлгээ болон бусад асуудлууд энд бас яригдах ёстой. Энэний тухай бид нар ярьсангүй. Монголын Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу бусад ХК-ууд сайн яваад зарим нэг дарга нь Хөдөлмөрийн баатар боллоо шүү дээ.

Би бол Монголын иргэд Говь-оосоо салах дургүй болов уу гэж бодож байна. Тийм учраас би ганц зүйл хэлэхэд нэгж хувьцаагаа 2,500 төгрөгөөс доошгүй үнээр авахаас нааш худалдаж авахгүй бол энэ талаар ярихгүй болов уу гэж бодож байна.

#### **ХАРИУЛТ:**

**ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан:** Компанид эргүүлж худалдах хүсэлтэй 4 гаруй хувийн хүмүүсээс эргүүлж хувьцаагаа худалдаж авсан байгаа. Компанийн хөрөнгийн үнэлгээ гэж ярьж байгаа. 2020 оны КОВИД-19-өөс болоод компанийн өөрийн хөрөнгө одоо хасах руугаа орсон байгаа. Тэгэхээр өнөөдөр хувьцааны үнэлгээг Говь ХК өөрөө тогтоохгүй, хөндлөнгийн үнэлгээний компанитай гэрээ байгуулж, хууль журам зааврын дагуу бүх зүйл явагдана.

**Хувьцаа эзэмшигч 4:** Нэмээд нэг асуулт байна. Гадаадаас хөрөнгө босгоно гэж байна. Одоо монголын хөрөнгийн зах зээлд олон компани бонд гаргаж байна. Тэгэхээр бид нар хувьцааны хэлбэрээ өөрчлөөд бондын хэлбэрт оруулаад 400-500 тэрбумын бонд гаргаж гадаадаас хөрөнгө татаж болохгүй юу?

**ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан:** Гадаадаас хөрөнгө татна гэж хэлээгүй. Нэмж хувьцаа гаргаж өр зээлээ бууруулна гэж би хэлсэн.

**Хувьцаа эзэмшигч 4:** Буруу ойлгосон байж магадгүй. Бас нэг юм хэлэхэд танай компанийн гадаадын иргэн хувьцаа эзэмшигчид, ялангуяа Япон хувьцаа эзэмшигчид их хэмжээг эзэмшиж байсан. Тэд гараад явсан. Хэчнээн төгрөгөөр нэгж хувьцааг нь үнэлж тооцоо хийсэн байдаг бол? Тэрийг бидэнд хэлж болох уу?

**ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан:** 239 төгрөгөөр худалдаж авсан байгаа.

**Хувьцаа эзэмшигч 4:** Тэр нь бол цаасан дээр тэгсэн байх. Харин хаалганы ард талд яаж тохирсон юм бол?

**ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан:** Ямарваа нэг тийм хаалттай юм байгаагүй. Бүх зүйл ил тод брокерын компанитай гэрээ байгуулаад явсан. Хувьцаагаа худалдаж байгаа хүмүүстэй бид ч уулзаагүй. Би Ди Сек компаниар зуучлуулж тэр хүмүүс бидэнд санал тавиад худалдаж авсан л зүйл болсон.

**Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр:** Эргүүлж авах нэгж хувьцааны үнэ маргааш гарах байгаа. Хөндлөнгийн компани үнэлгээ хийж байгаа. Хувьцааны үнэлгээгээ яаж хийх вэ гэвэл орлогын, өртөгийн, зах зээлийн гэсэн аргуудыг ашиглаж хийж байгаа. Тэрийг МХБ-ээс сүүлийн 6 сарын дундаж ханш ирэхээр харьцуулж байгаад маргааш ТУЗ-өөс энэ тогтоол гарах байгаа.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Та бүхэнд нэмэлт асуулт байхгүй бол асуулт хариултын хэсэг маань энд хүрээд өндөрлөж байна. Танд нэмэлт асуулт болон санал хүсэлт байвал таныг бүртгүүлэхэд өгсөн жижиг санал хүсэлтийн хуудсанд бичээд танхимын хойд хэсэгт байрлах санал хүсэлтийн хайрцагт хийнэ үү. Бид бүхэн хүн бүрийн бичсэн хүсэлтийг уншаад эргэн холбогдох болно. Үргэлжлүүлэн та бүхэнд санал өгөх зааварчилгааг танилцуулъя.

## 5. САНАЛ ХУРААЛТ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ санал өгөх зааврыг танилцуулан, санал хураалтыг албан ёсоор нээж нийт санал хураалт нийт 8 минут үргэлжлэв.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Саналын хуудсаар санал авч эхэллээ. Та бүхэн танилцуулсан зааврын дагуу саналын хуудсыг бөглөн танхимын баруун гар талд байрлах Тооллогын комиссын ширээн дээрх шар өнгөтэй саналын хайрцагт хийнэ үү. Хэрэв саналын хуудас бөглөхөд ойлгомжгүй зүйл гарвал та зааланд байгаа манай ажилтнуудаас болон Тооллогын комиссоос асууна уу.

## 6. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ НЭГТГЭХ

Тооллогын комисс саналын хайрцгийг задлан, санал хураалтын дүнг нэгтгэв. Нийт 20 минут үргэлжлэв.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Саналыг нэгтгэж дууссан тул Санал хураалтын дүнг танилцуулж, тогтоолыг батлуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Хатагтай Мөнхзулыг та бүхний өмнө урьж байна.

## 7. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

*Тооллогын комиссын дарга Т.Мөнхзул танилцуулав.*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 67.3, Говь ХК-ийн дүрмийн 6.1.10-6.1.16 заалтыг удирдлага болгон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Нийт **89.36** хувийн саналын эрхтэй **697,093,259** ширхэг хувьцааны **505** ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.
2. 2025 оны 09-р сарын 08-ны өдөр санал хураах хайрцагаар **87.45** хувийн саналын эрхтэй **682,226,560** ширхэг хувьцааны **30** ширхэг саналын хуудас хураасныг дурдсугай.
3. Урьдчилж ирүүлсэн саналын хуудасны хувьд, цахим хаягаар дамжуулж **0.00** хувийн саналын эрхтэй **191** ширхэг хувьцааны **1** ширхэг саналын хуудас, компанийн байранд **1.91** хувийн саналын эрхтэй **14,866,508** ширхэг хувьцааны **474** ширхэг саналын хуудас тус тус урьдчилж ирүүлснийг дурдсугай.
4. Нийт саналын хуудаснаас **0.00** хувийн саналын эрхтэй **6,401** ширхэг хувьцааны **11** ширхэг саналын хуудас хүчингүй болсныг дурдсугай.
5. Компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.
6. Компанийн дүрмийг шинээр батлах асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Баярлалаа. Хурлаас гарах тогтоолын төсөлд санал хураалтын дүнг тусган танилцуулж, батлуулна уу.

## 8. ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

*ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.*

Тооллогын комиссын санал хураалтын үр дүнд үндэслэн хурлаас гарах дараах 2 тогтоолын төслийг танилцуулав.

1. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай
2. Компанийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Баярлалаа.Хуралдаа идэвхтэй оролцсон, хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч нартаа талархал илэрхийлье. Үүгээр манай хурлын үйл ажиллагаа өндөрлөж байна. Та бүхэнд баярлалаа.

Хурал 15 цаг 05 минутад өндөрлөв.

Хурлын даргалагч:


Хурлын дарга



Д.БААТАРСАЙХАН

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Засаглалын мэргэжилтэн



Г.ДЭМЧИГСЭЛМАА